



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1999 оны 9 сар 9 өдөр

Дугаар А-190

Улаанбаатар хот.

"Гурван тамир" бага сургууль байгуулах тухай

1. Монгол Улсын боловсролын тухай хуулийн 16, 17, 26 дугаар зүйл, Бага, дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийг үндэслэн англи хэл, математикийн гүнзгийрүүлсэн сургалттай "Гурван тамир" бага сургууль байгуулахыг үүсгэн байгуулагч /Д.Огтонбаатар/-д зөвшөөрсүгэй.

2. "Гурван тамир" бага сургуулийг улсын бүртгэлд бүртгэж, сургалт явуулах тусгай зөвшөөрөл, хяналтын үзүүлэлтийг Боловсролын тухай хууль гүүнд нийцүүлэн гаргасан журамд заасны дагуу олгож, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Боловсролын мэргэжлийн комисс /Д.Хадхүү/ Боловсролын газрын дарга /П.Дорж/, Баянгол дүүргийн засаг дарга /С.Эрдэнэ/-д тус тус даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИ

М.ОИХБОЛД